



Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн чанарын холбоотой хамтран “Сайн туршлага-2019” арга хэмжээг 2019.10.11-ний одор Торийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт зохион байгуулагдлаа.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, вйлчилгээнд тэргүүн туршлага нэвтрүүлэх, бүтээлч санал санаачилгыг дэмжих, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготой тус арга хэмжээг 2017 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж буй богоод энэ жил НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллага, орхийн эрүүл мэндийн тов оролцсоноос НИЙСЛЭЛИЙН ОРГОО АМАРЖИХ ГАЗАР нь:

-“КАДАВР ДЭЭРХИ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДУРАНГИЙН МЭС ЗАСАЛ ХИЙХ АРГАЧЛАЛ” бүтээлээр амжилттай оролцож, шилдэг бүтээлээр шалгарсан тул сайн туршлагын санд бүртгэж ШИЛДЭГ БҮТЭЭЛЭЭР ГЭРЧИЛГЭЭ

-Сувилахуйн тусламж, вйлчилгээний, чанар, хвртээмжийг сайжруулахад чиглэсэн шинэ технологи, арга аргачлал номинацид “ҮЙЛЧЛҮҮЛЭГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

СОЛИЛЦОХ, ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦЭХ” загвар бүтээлээр ТЭРГҮҮН байранд шалгарч оргомжлол, монгон шагнал

-Эмнэлгийн тусламж, үйлчилгээний сайн туршлага шалгаруулах “Сайн туршлага-2019” арга хэмжээнд санал, санаачилга гарган амжилттай оролцсон тул:

- Кадавр дээрх эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал хийх аргачлал
- Мэс заслын омнох шалгах хуудас
- Үйлчилгээний соёлын заавар
- Эмнэлгийн мэргэжилтний эх, нярай, үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл солилцох, ээлж хүлээлцэх загвар хуудас /ISBAR/
- Эмнэлгийн баримт бичигт тавигдах шаардлага зарчим
- Тарианы шахуурга тоног тохооромжийн тосол
- Ургийн хяналтын монитормыг эх барихын практикт нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлснээр перинаталь үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тосол
- Шинэ мэдээлэл-Шинэ санаа сэдэвт олон улсын бага хурлаар эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эмхтгэл хэвлүүлсэн
- Нярайн шарлалтын хялбар оношилгоо зэрэг загвар бүтээлүүдээр батламж авч амжилттай оролцлоо.

Арга хэмжээний хүрээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахад дэвшил гаргаж шилдэгээр шалгарсан болон гэрчилгээ авсан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг энэ сард багтаан зохион байгуулахаар болжээ.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд 2019 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн тэргүүн туршлагаа хуваалцаж, хэрхэн хэрэгжүүлсэн арга аргачлалаа дэлгэн үзүүлж буй “Сайн туршлага 2019” арга хэмжээнд НЭМГ-ын дарга Л.Томорбаатар болон харьяа эмнэлгийн удирдлагууд оролцож эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн бүтээлч ажлуудтай танилцлаа.

Тус арга хэмжээг зохион байгуулснаар эрүүл мэндийн байгууллагууд мэдлэг туршлага солилцож, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр, торол нэмэгдсэнээр иргэдэд хүргэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах юм. Тиймээс тус арга хэмжээнээс шалгарсан сайн туршлагыг эмхэтгэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан товхимол хэвлүүлэх юм байна.









